

САНХҮҮ ЭДИЙН ЗАСГИЙН ИХ СУРГУУЛЬ
БАКАЛАВРЫН ЗЭРЭГ ОЛГОХ ОРОЙ, ЭЧНЭЭ ХӨТӨЛБӨРТ
2018-2019 ОНЫ ХИЧЭЭЛИЙН ЖИЛД ОЮУТАН ЭЛСҮҮЛЭХ ЖУРАМ

1. Нийтлэг зүйл

- 1.1. СЭЗИС-ийн бакалаврын зэрэг олгох орой, эчнээ хөтөлбөрийн элсэлтийн үйл ажиллагаатай холбоотой харилцааг зохицуулахад энэхүү журмыг баримтална.
- 1.2. Элсэлтийн үйл ажиллагааг Сургалт, судалгаа шинжилгээ эрхэлсэн дэд захирал хянана.
- 1.3. Элсэлтийн комисс нь элсэхийг хүсэгчдийг бүртгэх, шалган магадлах, хяналт тавих, шийдвэр гаргах, санал гомдлыг барагдуулах зэрэг үндсэн үүргийг гүйцэтгэнэ.
- 1.4. Бакалаврын зэрэг олгох орой, эчнээ хөтөлбөрийн зорилго нь бизнесийн үйл ажиллагаа эрхлэхэд шаардагдах орчин үеийн системтэй мэдлэг, чадварыг хэрэглэгчдийн оршин суугаа газраас үл хамааран цаг зав, боломжид нь тулгуурлан хөгжүүлэх сургалтыг зохион байгуулахад оршино.

2. Тавигдах шаардлага

2.1 Боловсрол

- 2.1.1 Их, дээд сургуулийг бакалавр зэрэгтэй төгссөн;
- 2.1.2 3-аас доошгүй жилийн сургалттай техникум болон коллеж төгссөн;
- 2.1.3 Их, дээд сургуульд 60-аас багагүй кредит цуглуулан, амжилттай суралцаж байгаа оюутан;

2.2 Бусад

- 2.2.1 Хувийн зохион байгуулалт сайтай, ажил болон сургалтыг хослуулах боломжтой байх;
- 2.2.2 Зан харилцаа, ёс суртахууны доголдолгүй байх;
- 2.2.3 Сургалтын ачаалал даахуйц эрүүл мэндийн чадвартай байх;
- 2.2.4 Сургалтын төлбөр төлөх чадвартай байх

3. Бүртгэл

- 3.1 Орой, эчнээ, бямба гаргийн эчнээ, ухаалаг цахим хэлбэрээр элсэхийг хүсэгчид admission@ufe.edu.mn хаягаар, цахим хэлбэрээр бүртгүүлнэ. Бүртгэл жилийн турш үргэлжилнэ.
- 3.2 Бүртгэлийн хураамж нь 15000 төгрөг байна.
- 3.3 Сургуулийн ufe.edu.mn сайтад 2018-2019 оны хичээлийн жилийн оюутан элсүүлэх журам, бүртгэлийн заавар, сургалтын хэлбэр бүрийн элсэлтийн хугацаа, шалгаруулалт болон бусад мэдээллийг тухай бүрд, жилийн турш мэдээлэн, байршуулна.

4. Шалгаруулалт

- 4.1 Элсэхийг хүсэгчдээс эзэмшвэл зохих мэдлэг, чадвар, дадлыг эзэмшсэн эсэх болон тухайн мэргэжлийг эзэмшихээр суралцах шаардлага хангасан түвшинд байгаа эсэхийг тодорхойлох шалгалт авна.

Ухаалаг цахим хэлбэрээр элсэхийг хүсэгчид мэргэжил, хөтөлбөрийг сонирхсон шалтгаан, зорилгын талаар 200-300 үгтэй эсээ бичиж ирүүлнэ.

4.2 Тухайн хөтөлбөрт элсүүлэн сургах оюутны тоог сургалтын ажил эрхлэх тусгай зөвшөөрлийн хяналтын тоо, сургалтын хүчин чадалтай уялдуулан, жил бүр Сургалт, судалгаа шинжилгээний алба тогтооно.

5. Элсэгчийг бүртгэх

5.1 Орой, эчнээ, бямба гаргийн хэлбэрээр элсэлтийн шалгалт өгсөн элсэгчид элсэлт бүрийн өмнөх 7 хоногт баталгаажуулах бүртгэлд биечлэн ирж хамрагдана. Ухаалаг цахим хэлбэрээр суралцахыг хүсэгчдийн хүн тус бүрийн цахим шуудангийн хаягаар элсэн орсон тухай мэдэгдэл, оюутны кодыг элсэлт бүрийн өмнөх 7 хоногт илгээнэ.

5.2 Орой, эчнээ, бямба гаргийн эчнээ хэлбэрээр элсэхийг хүсэгчид (ухаалаг цахим сургалтад элсэгчдээс бусад) дараах материалуудыг бүрэн эхээр нь авчирч, өөрөө ирж бүртгүүлнэ. Үүнд:

5.2.1 Иргэний үнэмлэх, түүнтэй дүйцэх баримт бичиг (гадаад паспорт, жолооны үнэмлэх, тухайн орон нутгийн ИБМ-ийн байгууллагаас олгосон гэрэл зураг бүхий орлуулах түр баримт);

5.2.2 Их, дээд сургууль, коллеж, техникум төгссөн дипломын эх хувийг нотариатаар баталгаажуулсан хуулбарын хамт;

5.2.3 Тухайн суралцаж буй сургуулийн тодорхойлолт, дүнгийн хуулбар;

5.2.4 Сүүлийн 3 сар дотор авахуулсан, 3х4 хэмжээний цээж зураг 3 хувь;

5.2.5 Сургалтын төлбөр тушаасан баримт

СЭЗИСургуулийн:

Улаанбаатар хотын банкны 2612007984 тоот данс,

Хас банк 5000010393 тоот данс,

ХААН банк 5129032930 тоот данс (төлбөрийн баримт дээр элсэгчийн овог, нэр, регистрийн дугаарыг бичсэн байх)

2018-2019 оны хичээлийн жилд бакалаврын зэрэг олгох орой, эчнээ хөтөлбөрт оюутан элсүүлэх журмын хавсралт-1

Сургалтын хэлбэр, хугацаа, судлах кредит, суралцах хэлбэрийн ерөнхий танилцуулга

Мэргэжил	Сургалтын хэлбэр	Хугацаа, жил	Нийт судлах хичээлийн багц цаг	Үүнээс: Суралцах хэлбэр		Тавигдах шаардлага энэ журмын дугаар заалт
				Танхимд	Ухаалаг цахим	
Нягтлан бодох бүртгэл Санхүү Бизнесийн удирдлага	Орой	2	60	54	6	2.1.1
	Бямба	2.5	90	72	18	2.1.2; 2.1.3
	Эчнээ					
	Ухаалаг цахим	2.5	60	-	60	2.1.1
3		90	-	90	2.1.2; 2.1.3	
Бизнесийн эрх зүй	Орой Бямба	2,5	90	72	18	2.1.1

**2018-2019 оны хичээлийн жилд бакалаврын зэрэг олгох
орой, эчнээ хөтөлбөрт оюутан элсүүлэх журмын хавсралт-2**

Суралцах цаг хугацааны ерөнхий жишиг хуваарь: багц цаг (кредит), модулиар

Сургалтын хэлбэр	Судлах кредит	Хичээлийн жил 1						Хичээлийн жил 2					Хичээлийн жил 3				
		I улирал		өвөл/ зун	II улирал		зун/ өвөл	I улирал		өвөл/ зун	II улирал		I улирал		Өвөл/ зун	II улирал	
		M1	M2	M3	M4	M5	M6	M7	M8	M9	M10	M11	M12	M13	M14	M15	M16
Орой, бямба, эчнээ	60+4	9	9	3	9	9	3	9	9+4								
	90+4	9	9	6	9	9	6	9	9	6	9	9+4					
Ухаалаг цахим	60+4	6	6	6	6	6		6	6	6	6	6+4					
	90+4	6	6	6	6	6		6	6	6	6	6	6	6	6	6	6+4

Ухаалаг цахим хэлбэрээр суралцана.

+4 1 кредит дадлага, 3 кредит төгсөлтийн шалгалт

Холбоо барих утас: Орой, эчнээ хөтөлбөр – 70150261

Цахим хуудас: www.ufe.edu.mn ; facebook.com/ufeinfo

Цахим шуудангийн хаяг: ept@ufe.edu.mn